

## ЁС ЗҮЙН ХОРООНЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 12 сарын 28

Улаанбаатар хот

### **Зорилго:**

Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, хамт олны соёлыг дээшлүүлэх.

### **Төлөвлөгөө:**

Газрын ёс зүйн хорооны бүрэлдэхүүн хуралдаж, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Газрын даргын 2019 оны 03 сарын 27-ний өдрийн А/ 26 тушаалаар батлуулсан. Уг төлөвлөгөөнд хувь хүний харилцаа, зан суртахууны хөгжлийг дэмжих чиглэлийн 2 удаагийн сургалт, хамт олны уур амьсгал, багаар ажиллах байдлыг дэмжих зорилго бүхий 2 удаагийн арга хэмжээ “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”- ыг боловсруулан батлуулж хэрэгжилтыг ханган ажиллах болон хууль, журмын хүрээнд зохион байгуулах бусад чиг үүргийн ажлыг төлөвлөн ажилласан. /Төлөвлөгөөг хавсаргаав./

### **Хэрэгжилт, үр дүн:**

Хувь хүний харилцаа, зан суртахууны хөгжлийг дэмжих чиглэлийн 2 удаагийн сургалтын хувьд:

1. “Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлага, зан үйл” сэдэвт сургалтыг Удирдлагын Академийн ТЗ-ны Төрийн Удирдлагын тэнхэмийн багш М.Амартүвшинтэй хамтран,
2. “Хувь хүний ёс зүй”, “Харилцааны соёл, байгууллагын соёлыг хөгжүүлэх нь”, “Хамт олны эерэг хандлага нөлөөлөл” сургалтыг Их засаг Их сургуулийн Н.Үнэнчимэгтэй хамтран,

Хамт олны уур амьсгал, багаар ажиллах байдлыг дэмжих зорилго бүхий 2 удаагийн арга хэмжээний хүрээнд:

1. "Ажлын цагийн үр бүтээмжийг дээшлүүлэх өдөр", "Эерэг хандлага, зан үйлийг дэмжих өдөр", "Талархлын өдөр", "Нээлттэй мэдээллийн өдөр", "Асуулт хариултын өдөр"-ийн хүрээнд ажил зохион байгуулсан байна.
2. Зохистой дадал хэвшлийг өөртөө төлөвшүүлж буй албан хаагчийг судалгааны аргаар тодруулан, эерэг хандлагыг сурталчилсан байна.

Ёс зүйн хорооны чиг үүргийн дагуух ажлын хүрээнд:


1. Монгол улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн Захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрмийн 1.2 дахь заалтын дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын “Ёс зүйн дүрэм” –ийг боловсруулан Газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/80 дугаар тушаалаар батлуулсан хэрэгжүүлэн ажиллаж байна.
2. Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, Төрийн албаны ёс зүйг дээшлүүлэх, албан хаагчийн эрх, үүрэг болон хориглох заалт тэр дундаа үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллаж буй албан хаагчийн хориглох зүйлийг тодорхой тусгуулах талаар санал боловсруулахад хамтран ажиллаж, төслийг нийт албан хаагчаас санал авах, баталгаажсан хувилбарыг танилцуулж ажилласан.

3. Авилгатай тэмцэх газраас ирүүлсэн саналыг үндэслэн 2019 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн А/127 тоот тушаалаар “Ёс зүйн дүрэм” болон гэрээг шинэчлэн батлуулсан. /Саналыг хавсаргав./
4. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг мэдээг улирал бүр НЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс хүргүүлж ажилласан.

**Цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх дүгнэлт:**

1. Ёс зүйн хороо болон Сахилга, хариуцлагыг дээшлүүлэх байнгын комиссын уялдаа, хамтын ажиллагааг хангаж, 2020 онд хэрэгжүүлэх ажил, үйлчилгээний зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг оновчтой тусгах, хуваарилах тал дээр хамтран ажиллах.
2. Албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагыг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж “Албан хаагчийн тухайн жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнэх шалгуур үзүүлэлт түүнийг үнэлэх аргачлалын талаарх журам боловсруулах ажлын хэсэг”-т саналыг танилцуулж ажиллах.

ТАНИЛЦСАН:  
ЁС ЗҮЙН ХОРООНЫ ДАРГА



Д.ЖАРГАЛМАА

БОЛОВСРУУЛСАН:  
ЁС ЗҮЙН ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА (С. Лувсансодном)



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН "ЁС ЗҮЙН ХОРОО"-НЫ ТАЙЛАН

Хэрэгжүүлэх арга хэмжээ /Байгууллагын гүйцэтгэлийн	Арга хэмжээний гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт /тоо, хувь, чанар/	Тухайн жилийн хүрэх түвшин	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ	Ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт
"Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлага, зан үйл" сэдэвт сургалт, ярилцлага зохион байгуулах.	<p>Чанар: Сургалтаар гүйцэтгэлийн болон үр дүнгийн гэрээг дүгнэх, ёс зүй, сахилгын зөрчлийг тооцох, хариуцлага хүлээлгэх чиглэлээр холбогдох хууль, дүрэмд орсон өөрчлөлтийг таниулсан байх.</p> <p>Тоо хэмжээ: 2 удаа нийт албан хаагчийг хамруулна.</p>	Ёс зүйн зөрчил үүсээгүй байна.	"Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага" сэдэвт сургалт, ярилцлага зохион байгуулах.	Чанар: Сургалтаар гүйцэтгэлийн болон үр дүнгийн гэрээг дүгнэх, ёс, зүй сахилгын зөрчлийг тооцох, хариуцлага хүлээлгэх чиглэлээр холбогдох хууль дүрэмд орсон өөрчлөлтийг таниулж, сургалтын үр өгөөжийг судалгаагаар дүгнүүлсэн байна.
			"Төрийн албан хаагчийн хандлага, зан үйл" сэдэвт сургалт, ярилцлага зохион байгуулах.	Чанар: Соён гэгээрүүлэх нээлттэй ярилцлага зохион байгуулсан байх.
"Ёс зүйн 7 хоног" аян зохион байгуулах.	<p>Чанар: "Ажлын цагийн үр бүтээмжийг дээшлүүлэх өдөр", "Эерэг хандлага, зан үйлийг дэмжих өдөр", "Талархлын өдөр", "Нээлттэй мэдээллийн өдөр", "Асуулт хариултын өдөр"-ийн хүрээнд ажил зохион байгуулсан байна.</p> <p>Тоо хэмжээ: Ажлын 5 өдөр</p>		"Ёс зүйн 7 хоног" аян зохион байгуулах.	<p>Чанар:</p> <p>"Ажлын цагийн үр бүтээмжийг дээшлүүлэх өдөр", "Эерэг хандлага, зан үйлийг дэмжих өдөр", "Талархлын өдөр", "Нээлттэй мэдээллийн өдөр", "Асуулт хариултын өдөр"-ийн хүрээнд ажил зохион байгуулсан байна.</p> <p>Тоо хэмжээ: 5 удаа</p>
Ёс зүйн хэм хэмжээ дээшлүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах.	<p>Чанар: Зохистой дадал хэвшлийг өөртөө төлөвшүүлж буй албан хаагчийг судалгааны аргаар тодруулан, эерэг хандлагыг сурталчилсан байна.</p> <p>Тоо хэмжээ: 3 удаа нийт албан хаагчийг хамруулна.</p>	Ёс зүйн хэм хэмжээ дээшлүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах.	<p>Чанар: Зохистой дадал хэвшлийг өөртөө төлөвшүүлж буй албан хаагчийг судалгааны аргаар тодруулан, эерэг хандлагыг сурталчилсан байна.</p> <p>Тоо хэмжээ: 3 удаа нийт албан хаагчийг хамруулна.</p>	